# БАТ-ӨЛЗИЙ СУМЫН АВИЛГЫН ЭСРЭГ
# 2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

| Д/д | Зорилт, Арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр | Хүрсэн түвшин, үр дүн | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| | Зорилт 1. Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлнэ. | | | | |
| 1. | 1.1. Авлигатай тэмцэх газраас бэлтгэсэн шторк, инфографик, нийтлэл, зурагт хуудас, цахим ном, гарын авлага зэргийг тухайн орон нутгийн албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ (фейсбүүк, твиттер, инстаграм), мөн лед дэлгэц, сурталчилгааны самбарт байршуулах зэрэг бүхий л боломжтой хэлбэрээр олон нийтэд хүргэх. | Түгээсэн мэдээлэл, иргэдийн хандалтын тоо, Харьяа, газар нэгжийг хамруулсан тоо | | Төсвийн 9 байгууллагын зүгээс АТГ-аас бэлтгэсэн мэдээ мэдээллийг олон нийтэд хүргэх чиглэлээр дараахь ажлуудыг хийж хэрэгжүүлсэн. Үүнд:<br>Телевизийн шторк, постер, хэвлэн олшруулах материалыг "Бат-Өлзий сумын нэгдсэн групп", Бат-Өлзий сумын Засаг даргын Тамгын газар зэрэг сошиал бүлгүүдэд байршуулсан нь 4500 гаруй иргэдийн хандалт авсан мөн ЗДТГ-ын гадна урсдаг самбар болон гадна байрлах том лэд дэлгэцээр дамжуулан иргэд олон нийтэд өдөр дутамдаа түгээн ажиллаж байна. | 90 |
| 2. | 1.2. Байгууллагын үйл ажиллагаанд авлигад өртөж болзошгүй чиглэлийг сонгон авлигын эрсдэлээс ангид байхад чиглэсэн, ёс зүй, шударга байдлыг уриалсан агуулга бүхий 2-оос доошгүй ажил зохион байгуулна. | Зохион байгуулсан ажлын үр дүнгээр | | Төрийн үйлчилгээний хүнд суртлыг багасгах, ёс зүйтэй төрийн албыг төлөвшүүлэх, авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, хуулиар хүлээсэн үүргээ хэрэгжүүлэхэд нь дэмжлэг туслалцаа үзүүлэх зорилгоор | 100 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | Авлигын эсрэг хууль, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Шилэн дансны тухай хуульд заасан шаардлагуудын дагуу төрийн байгууллагуудад үүрэг чиглэл хүргүүлж албан байгууллагуудын дотоод хурлуудаар мэдээлэл хийж төрийн албан хаагч нар мэдээллийг түгээж ажилласан. Авлигын нийгмийн хор аюулыг иргэд, олон нийтэд ухуулан таниулах ажлыг цахимаар сурталчилсан. Авлигын эсрэг чиглэлээр бэлдсэн видео болон радио контент, зурагт хуудас, нугалбар, подкаст, үзүүлэн таниулах хуудас, мэдээллийн самбар, видео болон цахим хичээл зэргийг сумын цахим хуудас, олон нийтийн сүлжээ Facebook, нийтийн тээвэр, сурталчилгаа, гудамжны самбар болон дэлгэц, хэд хэдэн төрөл хэлбэрээр түгээсэн. Байгууллагууд дотооддоо, албан хаагчдад Авлигын тухай ойлголт, түүнээс урьдчилан сэргийлэх сургалтыг зохион байгуулсан. Тус сургалтад 4 байгууллагын 85 албан хаагч хамрагдсан. | |
| | Зорилт 2. Авлигын эсрэг сургалт зохион байгуулах, сургалтад хамруулна. | | | | |
| 3. | 2.1. “Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх журам”-ыг хэрэгжүүлэх. | Олон нийтийн хяналт хэрэгжүүлсэн тоо | | Аудитын хяналт, шалгалтын дүгнэлтээр өгсөн зөвлөмжийг сумын веб хуудас, шилэн дансны нэгдсэн систем, Бат-Өлзий сумын | 100 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | нэгдсэн фейсбүүк групп, Өв.Бат-Өлзий сумын санхүүгийн алба пэйж хуудаст байршуулан иргэдэд түгээсэн мөн байгууллагын болон санхүүгийн албаны мэдээллийн самбарт байршуулан ажиллаж байна. | |
| 4. | 2.2. Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагаанд иргэний нийгмийн оролцоо, хамтын ажиллагааг нэмэгдүүлэх. | Хамтран ажилласан байгууллага, арга хэмжээний тоо | | Байгууллагын цахим хуудсанд байгууллагын авлигын эсрэг төлөвлөгөө болон холбогдох хууль тогтоомжийг байршуулж ажилласан. Төлөвлөгөө хэрэгжүүлэхэд шаардагдах төсөв хөрөнгийг тухай бүр нь шийдвэрлэж ажилласан. Авлигын эсрэг соён гэгээрүүлэх ажлын хүрээнд хэвлэл мэдээллийн хэрэгсэл, цахим орчинг ашиглан авилгын эсрэг шторк болон бусад мэдээллийг сум, байгууллагын түвшинд түгээн сурталчилах талаар зохион байгуулалтын арга хэмжээг авч ажлласаны дүнд нийт давхардсан тоогоор 800 гаруй иргэн, төрийн албан хаагчдад цахим хэлбэрээр сурталчилж ажиллав.<br>Мөн сумын нэгдсэн цахим хуудас http://www.bat-ulzii.ov.gov.mn/ сайтын “Ил тод байдал” цэс, “Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх” хэсэг, Бат-Өлзий сум Facebook хуудсуудад тус тус байршуулж, иргэнд мэдээ мэдээллийг түгээв. | 100 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 5. | 2.3. Төсвийн хөрөнгөөр санхүүжих хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилтийн талаарх мэдээллийн нээлттэй, ил тод байдлыг нэмэгдүүлж, иргэн, иргэний нийгмийн байгууллагын оролцоог хангах | Ил тод байршуулж мэдээлсэн мэдээллийн тоо | | Бат-Өлзий сумын Засаг даргын Тамгын газар /bat-ulzii.ov.gov.mn/ цахим хуудсанд үйл ажиллагааны мэдээлэл, хүний нөөц, төсөв, санхүү, худалдан авах ажиллагаа, үзүүлж байгаа үйлчилгээний мэдээллийг ил тод нээлттэй байршуулсан. Мөн ЗДТГ-ын пэйж хуудас, ЗДТГ-ын мэдээлэл урсдаг самбараар дамжуулан иргэдэд мэдээллийг тогтмол хүргэж байна. | 100 |
| 6. | 2.4. Байгууллагын үйл ажиллагаа, үйлчилгээний хүнд суртал чирэгдэлтэй холбоотой ирүүлсэн гомдол, мэдээлэлд дүн шинжилгээ хийж, үр дүнд суурилсан арга хэмжээг хэрэгжүүлэх | Дүн шинжилгээ хийсэн мэдээлэл | | Төрийн үйлчилгээний хүнд суртлыг багасгах, ёс зүйтэй төрийн албыг төлөвшүүлэх, авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, хуулиар хүлээсэн үүргээ хэрэгжүүлэхэд нь дэмжлэг туслалцаа үзүүлэх зорилгоор Авлигын эсрэг хууль, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Шилэн дансны тухай хуульд заасан шаардлагуудын дагуу төрийн байгууллагуудад чиглэл хүргүүлсэн.<br>Авлигын нийгмийн хор аюулыг иргэд, олон нийтэд ухуулан таниулах ажлыг цахимаар сурталчилсан. Авлигын эсрэг чиглэлээр бэлдсэн видео болон радио контент, зурагт хуудас, нугалбар, подкаст, үзүүлэн таниулах хуудас, мэдээллийн самбар, видео болон цахим хичээл зэргийг сумын цахим | 100 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | хуудас, олон нийтийн сүлжээ Facebook, нийтийн тээвэр, сурталчилгаа, гудамжны самбар болон дэлгэц, хэд хэдэн төрөл хэлбэрээр түгээсэн. Байгууллагууд дотооддоо, албан хаагчдад Авлигын тухай ойлголт, түүнээс урьдчилан сэргийлэх сургалтыг зохион байгуулсан. Тус сургалтад 4 байгууллагын 135 албан хаагч хамрагдсан. | |
| 7. | 3.1. Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах чиглэлээр тухайн байгууллагаас цахимаар иргэд, олон нийтэд үзүүлж буй цахим үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх чиглэлээр арга хэмжээ зохион байгуулах. | Зохион байгуулсан үйл ажиллагааны тоо | | Цахимаар иргэд, олон нийтэд үзүүлж буй цахим үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх чиглэлээр Киоск болон түц машиныг суурилуулснаар иргэд цахим үйлчилгээг 24 цагаар түргэн шуурхай чирэгдэлгүй авч байна. | 100 |
| 8. | 3.2. Байгууллагын дотоод хяналтын механизмыг сайжруулж, албан хаагчдыг авлига, ашиг сонирхлоос ангид байхад чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлэх. | Зохион байгуулсан үйл ажиллагааны тоо | | Төрийн байгууллагуудын ажилтан албан хаагчдыг авлига, ашиг сонирхлоос ангид байхад чиглэсэн сургалт мэдээллүүдийг байгууллагын хурлууд болон дотоод группээр дамжуулан тогтмол хүргэж ажиллаж байна. Байгууллагуудын дотоод хяналтын багийг шинэчлэн байгуулж үүрэгжүүлэн тухайн жилд хийгдэх ажлын төлөвлөгөөг боловсруулан хэрэгжилтийг хангаж өдөр дутмын үйл ажиллагаанд хяналт тавин гарсан алдаа дутагдалд зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэн ажиллаж байна. | 90 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 9. | 3.3. Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр төсвийн шууд захирагч болон санхүүгийн ажилтнуудын нэгдсэн сургалт, зөвлөгөөнд хамрагдах | Зохион байгуулсан үйл ажиллагааны тоо | | Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмийг бүх ажилтан, албан хаагчдад танилцуулж, ёс зүйн зөрчил гаргахгүй байх баталгаа гаргуулж, дотооддоо соён гэгээрүүлэх сургалт, сурталчилгаа зохион байгуулан, ёс зүйн зөрчил гаргахаас урьдчилан сэргийлж ажилласан. Соён гэгээрүүлэх сургалтыг байгууллагууд нийт 4 удаа зохион байгуулж 135 албан хаагч хамрагдсан. 2024 онд ёс зүйн зөрчил гаргасан албан хаагч бүртгэгдээгүй. | 70 |
| 10. | 4. Байгууллагын шударга байдлын үнэлгээг ахиулж, иргэдэд үйлчилж буй үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах. | Хэлтсүүдийн иргэдэд үзүүлсэн үйлчилгээ | | Засаг даргын Тамгын газар Төрийн үйлчилгээний нэгдсэн төв”-д төрийн үйлчилгээг иргэдэд хуулийн хүрээнд нэг цэгээс хүргэж байна. Байгууллагуудаас үзүүлж буй төрийн үйлчилгээг үзүүлэхэд шаардагдах бичиг баримтыг ил тод байршуулж, гарын авлага бэлтгэн олшруулан иргэдэд тарааж, Цахимаар авах үйлчилгээний жагсаалтыг олон нийтийн сүлжээгээр иргэдэд сурталчлан таниулж, ЗДТГ-ын цахим хуудас, мэдээллийн самбар, Хууль, эрх зүйн хөтөч пэйж хуудсаар дамжуулан хүргэж байна.<br>http://bat-ulzii.ov.gov.mn/ цахим хуудсанд нээлттэй мэдээллүүдийг байршуулж, | 100 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | шинэчлэн, хяналт тавин ажиллаж байна. | |
| Нийт үнэлгээ | | | | | 95% |

БИЕЛЭЛТ ГАРГАСАН: ЗДТГ-ЫН ДАРГА /Н. БАТ-ЭРДЭНЭ /

ХЯНАСАН: ЗАСАГ ДАРГА / Н.ОРХОНТУУЛ /